



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2026 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/4

Улаанбаатар хот

Өр, орлогын харьцааны дээд хязгаарыг
шинэчлэн тогтоох тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт, 22¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 1 дүгээр тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1.Банкнаас шинээр олгох болон нөхцөлийг нь өөрчлөх хэрэглээний зээлд тооцох өр, орлогын харьцааг 45 хувиас хэтрүүлэхгүй байхыг бүх банканд үүрэг болгосугай.

2.Энэ тушаалыг 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А-56 дугаар тушаалын 1 дэх заалтыг 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мөнгөний бодлогын газар (Б.Баярдаваа), Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газар (Н.Ариунбат), Хяналт шалгалтын газар (Ц.Нарандалай)-т тус тус үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



С.НАРАНЦОГТ

1526010067